



“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Үндэсний Аудитын газар
САГ-ын Захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер:
Я.Самбууням
Утас: 261885

Аудитор: Н.Нямдаваа
Утас: 260512

Засгийн газрын IV байр
Бага тойруу

Улаанбаатар-46
Монгол улс
Цахим хаяг: www.audit.mn

“Атланта баланс аудит” ХХК
Захирал: Г. Жаргал
Утас: 99105629

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн
санхүүгийн тайлан

Хавсралт 4: Аудитын хураангуй
тайлан

Хавсралт 5: Зөрчлийн нэгтгэл

Хавсралт 6: Асуудлын бүртгэл

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АГУУЛГА

1.	Аудитын гэрчилгээ	
2.	Аудитын тайлан.....	1
2.1.	Оршил.....	1
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин.....	2
2.4.	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, түүний үр дүн.....	3-4
2.5.	Дотоод хяналт.....	5
2.6.	Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаархи мэдээлэл.....	5
2.7.	Шилэн дансны мэдээлэл.....	5
2.8.	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	6
2.9.	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	6
2.10.	Анхаарал татахуйц бусад асуудал.....	7
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	7
2.12.	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	7
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.15.	Санал, дүгнэлтийн хэлбэр үндэслэл.....	8
3.	Менежментийн захидал.....	9
3.1.	Үндсэн ба нэмэгдэл цалин.....	10
3.2.	Зардал, өртөг.....	11
3.3.	Авлага, өглөг.....	12
3.4.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба дансны төлөвлөгөө.....	13
3.5.	Анхан шатны баримт.....	14
4.	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	15
4.1.	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	15- 16
4.2.	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	17
4.3.	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан/.....	18
4.4.	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19- 20
4.5.	Аудит хийгдсэн орлого, зардлын төлөвлөгөө ба гүйцэтгэл.....	21- 22



2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Дулааны гуравдугаар цахилгааны станц” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Г. Дамдинсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулааны гуравдугаар цахилгааны станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, батлагдсан заавар журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит

Харин тухайн санхүүгийн тайлан, дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 29-нөөс 2018 оны 03 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 14-нд эцэслэн баталгаажуулж, удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Атланта баланс аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Баярмаа, аудитор П.Нямаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, 2018 оны 02 дугаар сарын 10-ны өдөр “Атланта баланс аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК эх орноо хөгжилд хөтлөх эрчим хүчийг бүтээх эрхэм зорилгоо хэрэгжүүлэхээр байгаль орчинд ээлтэй, дэлхийн жишигт нийцсэн эрчим хүчийг үйлдвэрлэхээр ажиллаж, цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, цахилгаан, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээний 18 хувь, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 40 хувь, үйлдвэрийн технологийн хэрэглээний уурын 80 хувийг тус тус үйлдвэрлэж байна.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК нь Нисэх, Сонгино хайрхан дүүрэгт байрлах худгуудаар дамжуулан технологийн хэрэглээний ус татан авч дунд болон өндөр даралтын зуухуудад боловсруулан хүнс, ноос ноолуур, арьс шир, барилгын материалын үйлдвэрлэл зэрэг газруудыг технологийн уураар ханган ажиллаж байна.

Халаалтын улиралд Улаанбаатар хотын дулаан хангамжийн системд 7 мянган тонн усыг халаан үйлдвэрлэж байна. Мөн цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэн 35/110 кВ-н эрчим хүчний систем болон 6 кВ-ын шугамаар хэрэглэгчдэд нийлүүлж байна.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны онцлог, хууль эрх зүйн орчны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК нь үүргээ хэрэгжүүлэхдээ Компаний тухай, Эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиуд, холбогдох бусад хууль тогтоомжууд, Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Эрчим хүчний зохицуулах хорооны болон тус компаний төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол шийдвэр, дүрэм, журам, заавар аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай болон бусад холбогдох хуулиуд, НББӨУС, СТОУС-ын үйл ажиллагааны талаар байгууллага

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхдээ Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, /НББОУС/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй 10 дансанд 15 эрсдэлд үнэлгээ өгч, данс тус бүрээр нарийвчилсан горим, сорил 26-г гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК санхүүгийн үйл ажиллагаандаа 2013 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн санхүүгийн тайлангаа гаргасан байна.

Тус байгууллага арилжааны банкуудад төгрөгийн 7 харилцах данс, ам долларын 3 харилцах данс, касс зэргээр мөнгөн хөрөнгө байршуулсан бөгөөд тайлант хугацааны эцэст 5,202.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь харилцагч банкны үлдэгдлийн баталгаа, бэлэн мөнгөний тооллогын актаар баталгаажсан.

Нийт 3,277.7 сая төгрөгийн авлагаас дансны авлага 2,744.9 сая төгрөг буюу 83.7 хувь, татварын тооцооны авлага 504.3 сая төгрөг буюу 15.3 хувь, бусад авлага 28.5 сая төгрөг буюу 10 хувь тус тус тайлагнасан.


Дансны авлагын дотор Эрчим хүчний салбарын дотоод авлага 3 жилийн насжилтай буюу 90 гаруй хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 16,814.9 сая төгрөгийн их засвар, шинэчлэлийн ажил хийж гүйцэтгэж, үүнээс үндсэн тоноглолын их засварт 6,948.3 сая төгрөг, туслах тоноглолын их засварт 2,683.7 сая төгрөг, техник зохион байгуулалт арга хэмжээнд 6,301.2 сая төгрөг, барилгын их засварт 881,7 сая төгрөг тус тус зарцуулж үндсэн хөрөнгөнд капиталжуулсан байна.

Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар 4,700.0 сая төгрөгийн нэмэлт төсөв батлуулан 4,615.5 сая төгрөгийн техникийн усны шугам солих ажлыг хийж гүйцэтгэсэн.

2017 онд хөрөнгө оруулалтаар 1,719.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 7,390.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэсэн байна.

2017 онд зарлагдсан тендер, худалдан авах ажиллагаагаар бэлтгэсэн хөрөнгөнд найрийвчилсан горим гүйцэтгэхэд эрсдэл илрээгүй байна.



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит

Тус станц үндсэн ба туслах материал, төрөл бүрийн сэлбэг хэрэгсэл, хөдөлмөр хамгаалалын хувцас, аваарын нөөцийн материал худалдан авах тендерийг жил бүр зарлан бэлтгэж байна.

2017 оны 5 дугаар сарын 29-нд зарласан М-26-2017 дугаартай “Стопорны клапан” бэлтгэх тендерт санал ирээгүй тул “Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.2 дах заалтын дагуу дахин 2 дахь тендерийг зарласан боловч тендерийн материал авах хүсэлт ирээгүй, уг тендерийн ажил хийгдээгүй байна.

Авто машины сэлбэг бэлтгэн нийлүүлэх урилгыг 4 компанийн нэр дээр явуулснаас “Богд бизнес трейд” ХХК-иас ирсэн үнийн саналын материал шалгуурт нийцээгүй бөгөөд бусад компаниудаас үнийн санал ирээгүй тул “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн үнэлгээний комиссын шийдвэрээр зах зээлээс жижиглэн худалдаагаар бэлтгэсэн байна./ТАБ-СТА-В-3/

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлийн дагуу 399.1 сая төгрөгийн биет хөрөнгө, 34.4 сая төгрөгийн биет бус хөрөнгийг тус тус акталж, нийт 433.4 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан.

Дахин үнэлгээтэй үндсэн хөрөнгөнөөс 54 нэр төрлийн хөрөнгө данснаас хасагдаж, НББОУС 16 дугаар зүйлийн 16.41-д “Дахин үнэлгээний нэмэгдлийг дахин үнэлгээ хийгдсэн үндсэн хөрөнгө данснаас хасагдсан үед хуримтлагдсан ашиг дансанд нийт дүнгээр нэг л удаа шилжүүлж бүртгэх ба шилжүүлж бүртгэх дүн нь түүхэн өртгөөс байгуулсан элэгдэл, дахин үнэлэгдсэн дүнгээс байгуулсан элэгдлийн дүн хоорондын зөрүү байна” заасныг үндэслэн 47.8 сая төгрөгөөр дахин үнэлгээний дүн хорогдож, хуримтлагдсан ашиг өссөн байна.

2017 онд санхүүгийн тайлангийн зорилгоор үндсэн хөрөнгийн элэгдлийг байгуулж, элэгдлийн зардлыг тайлагнасан ба “санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-гаар хойшлогдсон татварын өглөгөөр 1,616.6 сая төгрөг бүртгэж тайлагнасан байна.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 11 дүгээр сарын 30–ны өдрийн 1/2616 дугаар шийдвэрийн дагуу үнэ төлбөргүй шилжүүлсэн үндсэн хөрөнгийг үйл ажиллагааны бусад зардалд оруулснаас уг зардлыг 1,551.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардал 730.2 сая төгрөгөөр хэтрэхэд нөлөөлсөн байна.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулгын аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Unicus” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлангаа гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Тус байгууллага нь “Дотоод аудитын үйл ажиллагааны дүрэм” дотоод аудитын стандартыг үндэслэн компанид учирч болзошгүй эрсдэлийг олж илрүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Дотоод аудит хийх ажлын төлөвлөгөөг Гүйцэтгэх удирдлагаар хянуулан, Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хорооны даргаар батлуулан ажиллаж 2017 онд 5.9 сая төгрөгийн зөрчил илрүүлэн тайлант жилд нийт 26 зөвлөмж өгч хэрэгжүүлсэн байна.

2.6 Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга

2017 онд 1077.7 сая квтц цахилгаан эрчим хүч боловсруулж, 901.9 сая квтц цахилгаан эрчим хүч түгээж төлөвлөгөөг 106.1 хувиар биелүүлсэн.

Тайлант онд 4104.6 мянган Г/кал дулаан үйлдвэрлэж, 2163.0 мянган Г/кал дулаан түгээж, үүнээс 261.2 мянган гкал уур, 1901.8 Г/кал ус халааж нийлүүсэн.


Түгээсэн дулааны эрчим хүч өмнөх оноос 85.3 мянган Г/кал, төлөвлөгөөнөөс 133.9 мянган Г/кал-аар буурсан, цахилгаан эрчим хүч өмнөх оноос 52.3 сая кВтц, төлөвлөгөөнөөс 52 сая кВтц-аар тус тус өссөн байна.

2017 оны зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 109,672.6 сая төгрөгийн орлоготой, 109,372.6 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 112,222.5 сая төгрөгийн орлого олж, 110,102.8 сая төгрөгийн зардал гарган 2,119.7 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төрийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан байх, талаар судалж үзэхэд Shilendans.gov.mn сайтад 2017 онд тендер, хөрөнгө оруулалт, худалдан авалт, санхүүгийн мэдээлэлүүд болон бусад чиглэлээр нийт 9 мэдээлэл оруулсан байна.

Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн а/2263 дугаар шийдвэрт “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангах



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит чиглэлээр эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын шилэн дансны мэдээлэлийг 3 дахин цөөрүүлж 7 нэр төрлийн мэдээлэлийг байршуулахаар оруулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 2 чиглэлээр эрсдэлд үнэлгээ өгч, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 10 дансанд нийт 26 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны төлөвлөсөн горим,

сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрт баримтжууллаа.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илэрхийлэгдээгүй байна. Материаллаг бус дараах зөрчилд зөвлөмж өгөв.

1. Тайлант 2017 оны үндсэн ба нэмэгдэл цалин нь 23,748.7 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс, гүйцэтгэлээр 25,490.6 сая төгрөг зарцуулагдаж 1,741.8 сая төгрөгөөр хэтэрсэн байна.


Шийдвэрлэсэн нь: УИХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 5 дахь зүйлд “Төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2. Борлуулалт маркетингийн зардалд 49.0 сая төгрөг зарцуулсан нь орлого үр дүнгийн тайланд борлуулалт маркетингийн зардлаар тусгаагүй, мөн ажилчдын нийгмийн зардал, баяр ёслол хүлээн авалтын зардлуудыг борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу бүртгэж тайлагнаж байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2013 оноос хойш шинэчлэгдээгүй, дансны төлөвлөгөө нь Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 13 дугаар тушаалаар хүчингүй болсон

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит

боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг мөрдөх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

4. Дансны авлагын 2,744.9 сая төгрөгийн үлдэгдэлд “Диспетчерийн үндэсний төв” ХХК-иас авах 2,484.9 сая төгрөгийн авлага 3 жилээс дээш насжилттай байгаа нь дансны авлагын 90 гаруй хувийг эзэлж байна.

Шийдвэрлэсэн нь: НББОУС-ын 24 дүгээр зүйлийн 24.18-д “Аж ахуйн нэгжид хамтарсан хяналт тавьдаг эсвэл түүнд мэдэгдэхүйц нөлөөлөлтэй аж ахуйн нэгж” заасны дагуу санхүүгийн тайланд тодруулга, толилуулгаар бэлтгэж тайлагнах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

5. Тайлант онд зарим зуухнуудын агрегат, цахилгаан турбогенератор, узель, насос, халаагч, хэмжүүрүүд солих, тоон систем шилжүүлэх зэргээр туслах тоноглолуудад хийгдсэн их засварын ажилд жагсаалт хавсаргасан ба тоноглол бүрээр НХМаягт ҮХ2 “Үндсэн хөрөнгийн өргөтгөл, сайжруулалт, их засварыг хүлээн авах баримт”-г үйлдээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад асуудал байхгүй.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

2017 онд зарлагдсан тендер, хийгдсэн их засвар, сайжруулалтын ажлууд 2018 онд давхардсан эсэхийг авч үзэх.


2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн нэмэгдэл цалингийн зардал хэтэрсэн, өртөг зардлын дансны ангилал зөрүүтэй зэрэг нийт 1,790.8 сая төгрөгийн материаллаг бус зөрчилд зөвлөмж хүргүүлээ

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд “Лайэн аудит” ХХК аудит хийн 10 зөвлөмж өгсөн байна. Үүнээс 370.6 сая төгрөгийн дүнтэй 3 зөвлөмжөөр залруулга хийж, 12,941.6 сая төгрөгийн дүнтэй 6 зөвлөмжид Сангийн яамнаас тодруулга авсан байна.

Цалин, нийгмийн даатгал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг хэтрүүлдэхгүй ажиллахаа биелэлтэнд дурьдсан байна.



2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Төлөвлөлтийн үе шатанд ТАБ-СТА-А-1 маягтыг ашиглан материаллаг түвшинг үнэлж нийт хөрөнгийг суурь үзүүлэлт болгон хөрөнгийн үнийн дүнгээс 1 хувиар буюу 2,075.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоох нь зүйтэй гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааварын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.



3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Үндсэн ба нэмэгдэл цалин

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

2017 оны үндсэн ба нэмэгдэл цалин гүйцэтгэлээр 25,490.6 сая төгрөг зарцуулж төлөвлөсөнөөс 1,741.8 сая төгрөгөөр хэтэрсэн нь төлөвлөгөөгөөр жилийн үр дүнгийн урамшууллыг 2,7 сарын цалинтай тэнцэх хэмжээгээр олгох байсныг, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор 4,5 сарын цалинтай тэнцэх хэмжээгээр олгосон нь батлагдсан төлөвлөгөө хэтэрсэн байна.

Эрсдэлүүд

Компани эдийн засгийн зохистой харьцаа алдагдах эрсдэл

ҮАГ-ын зөвлөмж

УИХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 5 дахь зүйлд “төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

ЭХЗХ-ноос 2017 оны 09-р сарын 01-нээс өндөр үнэтэй импортын цахилгааны өсөлтийг хязгаарлаж дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд цахилгааны түгээлтийг төлөвлөгөөнөөс илүү авч орлогоо нэмэгдүүлэх, энэхүү эх үүсвэрийг цалин болон бусад зардалд зарцуулах зөвшөөрлийг олгосон. Үүний дагуу бид 52.0 сая кВт.ц ЦЭХ нэмж үйлдвэрлэн, борлуулалтын орлогыг 2.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд нэмэгдсэн орлогыг ажиллагсдын жилийн үр дүнгийн урамшуулалд зарцуулах асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн ТУЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 22 өдрийн 31 тоот тогтоолоор 4.5 хүртэл сараар олгох шийдвэрийн дагуу олгосон.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.2. Зардал, өртөг

Тэргүүлэх ач холбогдол №1:

ҮАГ-ын ажиглалт:

Борлуулалт маркетингийн зардалд 49.0 сая төгрөг зарцуулсан нь орлого үр дүнгийн тайланд удирдлагын зардлын дүнд орсон, мөн ажилчдын нийгмийн зардал, баяр ёслол хүлээн авалтын зардлууд, зарим тэтгэмжүүд борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бүртгэсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу бүртгэж тайлагнаж байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд:

Өртөг зардлын хуваарилалт буруу тайлагнах, удирдлагын тайлан бүртгэл алдаатай байх,

Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



3.3 Авлага, өглөг

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Богино хугацаат авлага, өглөгийг бууруулж ажиллах ба богино хугацаат дансны өглөгийн 20 орчим хувь, дансны авлагын 90 гаруй хувь насжилт өндөртэй байгаа нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдэлд нийцэхгүй байна..

Эрсдэлүүд

Компани эдийн засгийн зохистой харьцаа алдагдах эрсдэл

ҮАГ-ын зөвлөмж

2017 оны санхүүгийн тайланд 2 жилээс дээш насжилттэй авлага өглөгийг бууруулж ажиллах талаар анхаарч эрчим хүчний системийн дотоодын авлагыг НББОУС-ын 24 дүгээр зүйлийн 24.18-д “аж ахуйн нэгжид хамтарсан хяналт тавьдаг эсвэл түүнд мэдэгдэхүйц нөлөөлөлтэй аж ахуйн нэгж” заасны дагуу санхүүгийн тайланд холбоотой талуудын тодруулга бэлтгэж толилуулах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Тус компани нь өр, авлага бууруулахад тогтмол анхаарч ажилладаг. Авлагын 90 гаруй хувийг цахилгааны борлуулалтын авлага эзэлж байна.

Эрчим хүчний салбарт цахилгааны борлуулалтын орлогыг “Нэг худалдан авагч”-тай загвараар төвлөрүүлдэг.

Борлуулалтын орлого төвлөрүүлэх хувийг Эрчим хүчний зохицуулах хорооноос улирал тутам тогтоож өгдөг.

ДҮТ ТӨХК-иас авах цахилгааны борлуулалтын авлага нь үнэ тариф болон борлуулалтын орлого төвлөрүүлэх хувиас хамааралтай байдаг учраас салбарын хэмжээнд

энэ асуудал шийдэгдэнэ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба дансны төлөвлөгөө

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг 2013 оноос хойш шинэчлэгдээгүй, тус компаний мөрдөж байгаа 2005 онд батлагдсан Эрчим хүчний салбарын дансны төлөвлөгөө нь Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 13 дугаар тушаалаар хүчингүй болсон нь санхүүгийн тайлангийн хэмжилт ба тохируулга баталж мэдэгдэлд нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Компани эдийн засгийн зохистой харьцаа алдагдах эрсдэл

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг мөрдөх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

“Нягтлан бодох бүртгэл хөгжүүлэх сан” ТББ–тай хамтран Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулах, дансны төлөвлөгөөг шинэчлэх ажил хийгдэж байна.



3.5 Анхан шатны баримт

Тэргүүлэх ач холбогдол 2:

ҮАГ-ын ажиглалт:

Тайлант онд туслах тоноглолуудад хийгдсэн их засварын ажилд жагсаалт хавсаргасан ба “Үндсэн хөрөнгийн өргөтгөл, сайжруулалт, их засварыг хүлээн авах баримт” НХМаягт-ҮХ2-г бүрдүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 заалт “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд:

Нягтлан бодох бүртгэлд анхан шатны баримт бүрдэл дутуу байх,

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. 2017 оны 12 дугаар сард бүртгэлд тусгасан ажил гүйлгээнүүдэд Их засвараас хүлээн авах актыг нөхөн бүрдүүлж байна.


4. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,161,121,152.03	5,202,558,660.64
Дансны авлага	3,296,798,603.22	2,744,921,303.42
Татвар, НДШ-ийн авлага	1,065,925,879.16	504,311,298.00
Бусад авлага	1,269,810,526.28	28,496,416.62
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	7,913,635,970.72	8,986,050,490.38
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,099,110,418.33	800,922,815.61
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	18,806,402,549.74	18,267,260,984.67
Эргэлтийн бус хөрөнгө	-	-
Үндсэн хөрөнгө	187,727,398,818.47	188,565,431,131.19
Биет бус хөрөнгө	594,777,611.01	524,593,012.10
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	204,765,158.10	204,765,158.10
Дуусаагүй барилга	418,917,210.18	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	188,945,858,797.76	189,294,789,301.39
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	207,752,261,347.50	207,562,050,286.06
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр	-	-
Дансны өглөг	1,468,285,285.10	1,916,321,196.23
Цалингийн өглөг	3,543,804,105.00	-
Татварын өр	99,562.92	-
НДШ-ийн өглөг	-	-
Богино хугацаат зээл	1,855,826,722.11	1,934,911,109.12
Хүүний өглөг	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	11,273,018.04	5,132,187.56
Нөөц /өр төлбөр/	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	83,466,923.00	174,695,430.50
Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит

Бусад	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,962,755,616.17	4,031,059,923.41
Урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат зээл	23,725,708,635.84	21,844,404,065.48
Нөөц /өр төлбөр/	-	-
Хойшлогдсон татварын өр	-	1,616,657,358.28
Бусад урт хугацаат өр төлбөр	-	2,627,103,921.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	23,725,708,635.84	26,088,165,344.76
Өр төлбөрийн нийт дүн	30,688,464,252.01	30,119,225,268.17
Эздийн өмч	-	-
Өмч: - төрийн	99,362,782,973.56	99,362,782,973.56
- хувийн	-	-
- хувьцаат	-	-
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	100,808,792,860.62	100,760,943,463.55
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг	-23,107,778,738.69	-22,680,901,419.22
Тайлангийн үеийн ашиг	-	449,460,782.40
Өмнөх үеийн ашиг	-23,107,778,738.69	-23,130,362,201.62
Эздийн өмчийн дүн	177,063,797,095.49	177,442,825,017.89
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	207,752,261,347.50	207,562,050,286.06



4.2 АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого (цэвэр)	104,906,622,195.43	110,679,297,492.49
Борлуулалтын өртөг	95,641,992,043.33	100,002,473,952.09
Нийт ашиг (алдагдал)	9,264,630,152.10	10,676,823,540.40
Түрээсийн орлого	57,599,795.07	57,655,682.78
Хүүний орлого	425,135,904.80	535,344,405.06
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	946,065,408.29	938,694,939.25
Орлогын дүн	1,428,801,108.16	1,531,695,027.09
Борлуулалт, Маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	7,070,053,464.42	7,228,740,598.47
Санхүүгийн зардал	492,857,405.63	461,213,982.14
Бусад зардал	2,157,247,216.96	997,126,274.05
Зардлын дүн	9,720,158,087.01	8,687,080,854.66
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	46,223,065.77	-5,981,561.26
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-742,206,483.23	-1,395,803,570.37
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Олз, гарзын дүн	-695,983,417.46	-1,401,785,131.63
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	277,289,755.79	2,119,652,581.20
Орлогын татварын зардал	42,513,590.48	1,670,191,798.80
Татварын дараах ашиг (алдагдал)	234,776,165.31	449,460,782.40
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	234,776,165.31	449,460,782.40
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	234,776,165.31-	449,460,782,40-
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-




4.3 АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(Төгрөгөөр)


Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	99,362,782,974.00	100,946,099,269.00	1,355,471,123.00	(20,726,458,476)	180,937,894,889.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(131,269,053.00)	(1,355,471,123.00)	(2,616,096,428.00)	(4,102,836,604)
Залруулсан үлдэгдэл	99,362,782,974.00	100,814,830,215.00	-	(23,342,554,904.00)	176,835,058,285.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				234,776,165.00	234,776,165.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		6,037,355.00			6,037,355.00
2016 оны 12 сарын 31-ээр	99,362,782,973.56	100,808,792,860.62		(23,107,778,738.69)	177,063,797,095.49
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-		449,460,782.40	449,460,782.40
Зарласан ногдол ашиг	-	-		-70,432,860.00	-70,432,860.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-47,849,397.07			
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	99,362,782,973.56	100,760,943,463.55		(22,680,901,419.22)	177,442,825,017.89



4.4 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	104,372,840,904.30	111,023,655,565.41
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	103,308,519,479.79	109,885,815,420.82
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	193,310,143.00	225,233,640.16
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	871,011,281.51	912,606,504.43
Мөнгөн зарлагын дүн (-)	86,321,626,013.09	92,782,051,444.89
Ажиллагчдад төлсөн	19,324,827,616.63	24,192,939,319.59
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,815,000,000.00	6,131,600,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	44,972,713,897.00	43,464,574,440.00
Ашиглалтын зардалд төлсөн	2,027,049,888.57	1,836,435,331.77
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,808,936,563.58	7,767,242,088.27
Хүүний төлбөрт төлсөн	114,499,134.72	73,663,323.69
Татварын байгууллагад төлсөн	6,391,482,502.74	7,330,696,894.81
Даатгалын төлбөрт төлсөн	76,916,430.00	119,331,949.00
Бусад мөнгөн зарлага	2,790,199,979.85	1,865,568,097.76
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,051,214,891.21	18,241,604,120.52
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	425,135,904.80	535,344,405.06
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	425,135,904.80	535,344,405.06
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	20,968,574,798.26	15,613,131,411.09
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,835,758,598.26	15,493,083,320.09
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	132,816,200.00	120,048,091.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Бусад	-	-



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит


Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-20,543,438,893.46	-15,077,787,006.03
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	
Мөнгөн орлогын дүн (+)	-	
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	
Төрөл бүрийн хандив	-	
Бусад	-	
Мөнгөн зарлагын дүн (-)	113,217,340.72	122,379,605.88
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	113,217,340.72	122,379,605.88
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		-
Төлсөн ногдол ашиг		-
Бусад		-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-113,217,340.72	-122,379,605.88
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-2,605,441,342.97	3,041,437,508.61
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,766,562,495.00	2,161,121,152.03
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,161,121,152.03	5,202,558,660.64

4.5. АУДИТ ХИЙГДСЭН 2017 ОНЫ ОРЛОГО ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БА ГҮЙЦЭТГЭЛ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(Мянган төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт + Хэмнэлт -	Хувь
Орлого:				
Борлуулалтын орлого	108,342,581.3	110,679,297.5	2,336,716.2	102%
Үйл ажиллагааны бус орлого	1,330,000.0	1,543,179.2	213,179.2	116%
Нийт орлогын дүн	109,672,581.3	112,222,476.6	2,549,895.3	102%
Зардал:				
Түлшний зардал	51,989,581.5	49,711,320.5	-2,278,261.0	96%
Усны зардал	272,572.6	119,895.2	-152,677.5	44%
Ус ашиглалтын зардал	517,355.0	392,722.8	-124,632.2	76%
Цахилгааны зардал	1,051,001.5	1,036,205.1	-14,796.4	99%
Туслах материал	152,624.1	142,730.4	-9,893.7	94%
Шатахуун	286,721.9	255,435.6	-31,286.3	89%
Тээвэр бэлтгэлийн зардал	2,470.0	2,148.0	-322.0	87%
Сэлбэг хэрэгсэл	100,567.1	93,874.4	-6,692.7	93%
Урсгал засвар	1,415,968.5	1,306,232.6	-109,735.9	92%
Хангамжийн материал	135,254.0	138,450.6	3,196.6	102%
Үндсэн ба нэмэгдэл цалин	23,748,775.4	25,490,591.6	1,741,816.2	107%
Нийгмийн даатгалын шимтгэл	3,088,363.5	3,296,733.4	208,369.9	107%
Албан томилолтын зардал	48,049.9	16,255.0	-31,794.9	34%
Контор хангамжийн зардал	59,554.1	50,829.2	-8,724.9	85%
Харилцаа холбооны зардал	43,551.2	33,415.9	-10,135.4	77%
Харуул хамгаалалтын зардал	49,674.0	44,502.9	-5,171.4	90%
Хөдөлмөр хамгааллын зардал	550,961.0	469,646.9	-81,314.1	85%
Даатгалын зардал	40,900.0	40,171.2	-728.8	98%
Байгаль орчин хамгаалах зардал	39,000.0	20,436.4	-18,563.6	52%
Гэрээт галын хэсгийн зардал	146,083.0	145,350.4	-732.6	99%
Гүйцэтгэх удирдлагын зардал	283,282.0	277,851.3	-5,430.8	98%
ТУЗ-ийн зардал	47,220.2	44,634.8	-2,585.4	95%
Төслийн зардал	82,375.4	86,699.4	4,324.0	105%
Борлуулалт маркетингийн зардал	64,810.0	49,018.0	-15,792.0	76%
ДҮТ-ийн зохицуулалтын зардал	5,851.9	9,949.7	4,097.8	170%
ЭХЗХ зохицуулалтын зардал	497,300.0	497,300.0	0.0	100%



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит

Сургалтын зардал	192,612.0	151,133.1	-41,478.9	78%
Урт хугацаат зээлийн хүүгийн зардал	461,214.0	461,214.0	0.0	100%
Бүтээмжийн зардал	44,000.0	19,903.7	-24,096.3	45%
Санхүүгийн аудит	35,000.0	28,000.0	-7,000.0	80%
Хэвлэл захиалга	1,673.7	3,955.7	2,282.0	236%
Галын аюулаас сэргийлэх зардал	35,000.0	30,027.2	-4,972.8	86%
Үндсэн хөрөнгийн элэгдэл	20,590,898.0	20,265,164.0	-325,734.1	98%
Үл хөдлөх хөрөнгийн татвар	570,064.1	570,064.1	0.0	100%
АТӨЯХ-ийн албан татвар	2,334.2	2,208.9	-125.3	95%
Газрын төлбөр	141,895.9	140,988.9	-907.0	99%
Бусад зардал	81,860.0	382,592.2	300,732.1	467%
Бүрэн өөрийн өртөг	106,876,419.9	105,827,652.9	-1,048,766.9	99%
АНЗардал	1,637,306.4	1,864,775.6	227,469.2	114%
Үндсэн үйл ажиллагааны зардал	108,513,726.3	107,692,428.5	-821,297.7	99%
Үйл ажиллагааны бус зардал	858,855.0	2,410,395.5	1,551,540.5	281%
Нийт зардлын дүн	109,372,581.3	110,102,824.1	730,242.8	101%
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	300,000.0	2,119,652.6	1,819,652.5	707%
ААНОАТатварын зардал	0.0	1,670,191.8	1,670,191.8	
Татварын дараах ашиг /алдагдал/	300,000.0	449,460.8	149,460.7	150%